

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Мөрөн сум
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: teqshdelqerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ийн партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Л.Наранбаатар
Утас: 89110525 Цахим хаяг: naraa_123@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	4
Аудитын гол асуудал	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	
5.3	
Зөвлөмж	1618
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

ТЭГЭЙН 1 - Улсын Стандарт
ДЭГЭЙН 2 - Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.24 № 01/154
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-УУЛ
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Г.АЗБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээллийг оруулна.

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба үйл ажиллагааны орлого 245.4 мянган төгрөг, улсын төсвөөс 340,564.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 33,659.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 65,247.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 2,258.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлууд байна. Засаглах эрх бүхий этгээдийн түвшин дэх харилцаанаас аудитын гол асуудлыг сонгоно.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Бусад асуудлын хэсэг

Бусад асуудлын хэсэгт аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудлыг

оруулна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Цагаан-Уул сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, түүнийг 97 хувь биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>53,021,209.00</u>	<u>100,110,449.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	33,659,668.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	33,659,668.00
3121	Төгрөг	00.00	33,659,668.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	33,659,668.00
35	БАРАА МАТЕРИАЛ	53,021,209.00	66,450,781.00
351	Түүхий эд материал	16,335,093.00	19,608,033.00
35110	Тусгай зориулалттай материал	15,793,733.00	19,326,933.00
35130	Эм боох материал	541,360.00	281,100.00
354	Хангамжийн материал	31,374,300.00	42,130,932.00
35410	Бичиг хэргийн материал	430,300.00	962,100.00
35420	Аж ахуйн материал	5,985,060.00	6,905,360.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,495,000.00
35450	Барилгын засварын материал	2,129,000.00	2,131,000.00
35460	Хүнсний материал	4,939,488.00	13,346,520.00
35470	Бусад хангамжийн материал	16,890,452.00	17,290,952.00
35600	Мал амьтад	5,311,816.00	4,711,816.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>412,513,747.93</u>	<u>425,815,650.02</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	412,513,747.93	425,815,650.02
392	Биет хөрөнгө	400,140,914.47	413,497,816.52
39201	Барилга, байгууламж, орон сууц	383,497,256.00	383,497,256.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53,682,396.88	-70,365,814.84
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	55,973,693.08	80,321,333.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,721,128.42	-17,424,470.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,772,806.00	21,922,606.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,226,688.89	-5,990,093.70
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,686,840.00	24,130,712.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,847,768.62	-5,282,013.99
39217	Ном	2,688,302.20	2,688,302.20
393	Биет бус хөрөнгө	12,372,833.46	12,317,833.50
39301	Програм хангамж	275,000.00	275,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-174,166.54	-229,166.50
39303	Бусад биет бус хөрөнгө	12,272,000.00	12,272,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>465,534,956.93</u>	<u>525,926,099.02</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>70,561.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,561.00	00.00
413	Өглөг	70,561.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	41,667.00	00.00
4136	Бусад өглөг	28,894.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	28,894.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>465,464,395.93</u>	<u>525,926,099.02</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	464,464,395.93	524,926,099.02
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	95,678,686.95	95,678,686.95
51101	Өмч: - төрийн	95,678,686.95	95,678,686.95
512	Хуримтлагдсан үр дүн	20,717,618.99	81,179,322.08

51210	Өмнөх үеийн үр дүн	20,717,618.99	20,717,618.99
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	60,461,703.09
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	349,068,089.99	349,068,089.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	465,534,956.93	525,926,099.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	374,089,542.08	451,057,692.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	337,611,409.08	45,245,692.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,895,909.08	45,245,692.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	245,480.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	245,480.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	318,715,500.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	318,715,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	523,533.00	405,812,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	340,564,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	340,564,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	349,033.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,533.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	65,247,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	65,247,200.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	174,500.00	00.00
1330	Төсвийн захирагчдаас	174,500.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	346,605,510.44	390,595,988.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,605,510.44	390,595,988.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	335,832,270.18	388,336,993.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,248,427.00	248,293,728.00
210101	Үндсэн цалин	140,576,468.00	185,111,878.00
210102	Нэмэгдэл	71,402,895.00	53,231,411.00
210104	Урамшуулал	15,269,064.00	9,950,439.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,422,331.84	31,012,512.00
210201	Тэтгэврийн даатгал	20,358,862.12	21,220,381.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,266,814.23	2,471,517.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,813,451.49	1,960,553.76
210204	Ажилгүйдлийн даатгал	449,584.70	485,391.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,533,619.30	4,874,667.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,325,567.90	35,576,078.70
210301	Гэрэл, цахилгаан	1,171,748.00	1,588,183.00
210302	Түлш, халаалт	30,903,819.90	33,312,896.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	674,999.70

2104	Хангамж, бараа материалын зардал	5,634,232.00	3,757,140.00
210401	Бичиг хэрэг	110,000.00	787,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,570,220.00	754,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	233,804.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349,033.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,500,340.00	2,005,500.00
210408	Бараа материал акталсны зардал	870,835.00	210,000.00
2105	Нормативт зардал	9,262,058.00	27,407,968.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,651,180.00	408,860.00
210502	Хоол, хүнс	7,380,478.00	26,999,108.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	230,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,098,200.00	5,594,000.00
210604	Урсгал засвар	3,098,200.00	5,594,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	664,800.00	571,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	571,667.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,106,653.44	36,123,899.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	578,500.00	4,977,390.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,769,400.00	1,507,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,758,753.44	29,639,409.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,773,240.26	2,258,995.30
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,912,408.16	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,912,408.16	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	860,832.10	2,258,995.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	860,832.10	2,258,995.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	27,484,031.64	60,461,703.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	27,484,031.64	60,461,703.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	355,019,133.00	406,057,480.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	318,715,500.00	245,480.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	245,480.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	245,480.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	245,480.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	318,715,500.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	318,715,500.00	00.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	36,303,633.00	405,812,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	340,564,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	340,564,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	349,033.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,500.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	174,533.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	35,954,600.00	65,247,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	35,954,600.00	65,247,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	328,329,133.00	372,397,812.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,329,133.00	372,397,812.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	317,555,892.74	370,138,816.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,147,309.00	248,364,289.00
210101	Үндсэн цалин	140,475,350.00	185,182,439.00
210102	Нэмэгдэл	71,402,895.00	53,231,411.00
210104	Урамшуулал	15,269,064.00	9,950,439.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,452,888.84	31,012,512.00
210201	Тэтгэврийн даатгал	20,380,363.12	21,220,381.25
210202	Тэтгэмжийн даатгал	2,269,078.23	2,471,517.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,815,262.49	1,960,553.76
210204	Ажилгүйдлийн даатгал	450,037.70	485,391.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,538,147.30	4,874,667.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,075,567.90	36,071,078.70
210301	Гэрэл, цахилгаан	1,171,748.00	1,588,183.00
210302	Түлш, халаалт	30,653,819.90	33,807,896.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	674,999.70
2104	Хангамж, бараа материалын зардал	12,526,657.00	00.00
210401	Бичиг хэрэг	237,700.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,320,220.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	233,804.00	00.00
210404	Ном, хэвлэл	198,100.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349,033.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,187,800.00	00.00
2105	Нормативт зардал	9,027,570.00	35,106,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,415,050.00	00.00
210502	Хоол, хүнс	7,280,120.00	35,106,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	332,400.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,018,200.00	7,100,000.00
210604	Урсгал засвар	3,018,200.00	7,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	70,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	664,800.00	571,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	571,667.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,572,900.00	11,913,130.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	403,500.00	9,213,130.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,169,400.00	2,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,773,240.26	2,258,995.30
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,912,408.16	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,912,408.16	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	860,832.10	2,258,995.30
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	860,832.10	2,258,995.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	26,690,000.00	33,659,668.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,690,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,690,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,690,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,690,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-26,690,000.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	33,659,668.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	33,659,668.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,678,686.95	349,428,767.99	-5,129,042.43	439,978,412.51
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	108,264.50	108,264.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,678,686.95	349,428,767.99	-5,020,777.93	440,086,677.01
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,998,048.22	-1,998,048.22
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,678,686.95	349,068,089.99	20,717,618.99	465,464,395.93
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,678,686.95	349,068,089.99	20,717,618.99	465,464,395.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	95,678,686.95	349,068,089.99	20,717,618.99	465,464,395.93
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	60,461,703.09	60,461,703.09
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	95,678,686.95	349,068,089.99	81,179,322.08	525,926,099.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	405,812,000.00	370,138,816.70	35,673,183.30	91.21
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	405,812,000.00	370,138,816.70	35,673,183.30	91.21
210	Бараа, үйлчилгээний зардал	405,812,000.00	370,138,816.70	35,673,183.30	91.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,742,000.00	248,364,289.00	29,377,711.00	89.42
210101	Үндсэн цалин	226,602,900.00	185,182,439.00	41,420,461.00	81.72
210102	Нэмэгдэл	46,591,300.00	53,231,411.00	(6,640,111.00)	114.25
210104	Урамшуулал	4,547,800.00	9,950,439.00	(5,402,639.00)	218.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,058,800.00	31,012,512.00	4,046,288.00	88.46
210201	Тэтгэврийн даатгал	23,937,000.00	21,220,381.25	2,716,618.75	88.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,776,200.00	2,471,517.57	304,682.43	89.03
210203	ҮОМШӨ ний даатгал	2,229,800.00	1,960,553.76	269,246.24	87.93
210204	Ажилгүйдлийн даатгал	557,400.00	485,391.60	72,008.40	87.08
210205	Эрүүл мэндийн даатгал	5,558,400.00	4,874,667.82	683,732.18	87.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,312,900.00	36,071,078.70	2,241,821.30	94.15
210301	Гэрэл цахилгаан	3,000,000.00	1,588,183.00	1,411,817.00	52.94
210302	Түлш, халаалт	32,312,900.00	33,807,896.00	(1,494,996.00)	104.63
210303	Цэвэр, бохир ус	3,000,000.00	674,999.70	2,325,000.30	22.50
2105	Нормативт зардал	34,871,100.00	35,106,140.00	(235,040.00)	100.67
210502	Хоол, хүнс	34,871,100.00	35,106,140.00	(235,040.00)	100.67
2106	Эд хогшил худалдан авах	7,100,000.00	7,100,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	7,100,000.00	7,100,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	814,000.00	571,667.00	242,333.00	70.23
210806	Мэдээллийн технологийн зардал	814,000.00	571,667.00	242,333.00	70.23
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	11,913,200.00	11,913,130.00	70.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,213,200.00	9,213,130.00	70.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,700,000.00	2,700,000.00	-	100.00
		405,812,000.00		405,812,000.00	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	405,812,000.00		405,812,000.00	-
122005	Улсын төсвөөс санхүүжих				

		405.812.000.00		405.812.000.00	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	33,659,668.00	(33,659,668.00)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	19.00	19.00		100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00		100.00
620003	Үйлчлэх ажилтан	9.00	9.00		100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна. Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд "Багш, ажилчдын сайн туршлага, арга зүйг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, Сургуулийн өмнөх боловсролын үнэлгээнд суурилсан арга зүйг хэрэгжүүлэх, бүсийн цэцэрлэгүүдтэй хамтын хөгжлийг нэмэгдүүлэх" гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд 7 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь Цагаан-Уул сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг 97 хувь биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна. Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг 2021 онд өөрчлөн найруулснаар "хувьсах зардал"-ыг улсын төсвөөс санхүүжүүлэх болсон байна. Засгийн газар болон Боловсрол шинжлэх ухааны яамнаас дараах шийдвэрүүдийг гаргасан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:

1. Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор "Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн", "Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр", "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал" баталсан байна.
2. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ" баталсан байна.

3. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
4. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу 2022 оны 01 сарын 31 өдрийн А/03 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 3 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан

боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 60,391.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	33,659.7	33,659.7
Авлага	0.0		
Бараа материал	53,021.2	66,450.8	13,429.6
Үндсэн хөрөнгө	412,513.7	425,815.6	13,301.9
Нийт хөрөнгө	465,534.9	525,926.1	60,391.2
Өр төлбөр	70.5	0.0	70.5
Засгийн газрын хувь оролцоо /Төрийн өмч/	95,678.7	95,678.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	20,717.6	81,179.3	60,461.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	349,068.1	349,068.1	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	465,534.9	525,926.1	60,391.2

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 33,659.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 13,429.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хүүхдийн хоолны материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 13,301.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 42,941.3 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 29,639.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 341,331.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 65,247.2 мянган төгрөг, нийт 406,578.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 2,510.0 мянган төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг хэвээр нь баталсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба тайлант

онд төрийн үйлчилгээний ажилчид орон нутгийн төсвөөс улсын төсөвт шилжсэнтэй, мөн өргөн хэрэглээний бараа материалын үнэ өссөнтэй холбоотой Боловсрол Шинжлэх ухааны сайдын тушаалаар төсөвт 1 удаа зохицуулалт хийгдэж төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтүүдээр анх баталсан улсын төсвийг нийт 1,733.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тус цэцэрлэг нь 2022 онд 100 хүүхдийн хүчин чадалтай ажиллаж нэг хүүхдийн нормоор тооцож авах санхүүжилт 325,759.2 мянган төгрөг байх байтал 340,512.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Тайлант онд 14,753.6 мянган төгрөгийн илүү санхүүжилт авсан нь төлөвлөлт үндэслэл муутай төлөвлөгдсөн байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувьд үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан улсын төсвөөс санхүүжих дүнг 1,733.2 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 340,564.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 65,247.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 340,564.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 33,659.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 65,247.2 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 2,258.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 369,893.3 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын төсвийг 33,309.0 мянган төгрөгөөр, Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлын төсвийг 340.2 мянган төгрөгөөр, ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардлын төсвийг 2,241.8 мянган төгрөгөөр, нийтлэг үйлчилгээний зардлын төсвийг 17.2 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолыг 10.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	ТШЗ-ийн байгууллагуудын тогтмол зардал	45,412.9	43,171.1	2,241.8	95.0
2	Нийтлэг үйлчилгээ	19,834.3	19,817.1	17.2	99.9
3	Эрүүл мэндийн үйлчилгээ	1,100.0	1100,0	-	100
4	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	34,871.1	34,860.6	10.5	99.9
5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,733.2	1733,2	-	100
6	Багшийн тасралтгүй хөгжил	1,100.0	1100,0	-	100
7	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	254,505.0	221,196.0	33,309.0	86.9
8	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	47,255.5	46915,3	340,2	99,3
	Нийт дүн	405,812.0	369,893.3	35,918.7	91.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус Хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Наранбаатар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыгсонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 346,605.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 6,932.1 мянган төгрөгөөр, мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын (80 хувиар) буюу 5,545.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйл илэрсэн болно. Үүнд: Тайлант онд эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ахмадын санд 5,600.0 мянган төгрөг шилжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт нийт 148 мэдээлэл оруулахаас 209,075.6 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 142 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 315,625.3 мянган төгрөгийн 20 гүйлгээний мэдээлэл оруулахаас 243,527.3 мянган төгрөгийн 13 мэдээлэл мэдээлээгүй, орлогын 55,698.0 мянган төгрөгийн 5 гүйлгээг буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд зөрчилтэй асуудал илрээгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар бичнэ.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	1	2140,0	1	2140,0	100,0
Нийт дүн	0	0	0	0	0

/мянган төгрөгөөр/

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлангийн толилуулгыг илэрхийлэхдээ нягтлан бодох бүртгэлээс зөрүүтэй илэрхийлсэн байсныг аудитын хугацаанд залруулсан болно.

Аудитаар нийт 516,098.1 мянган төгрөгийн алдаа¹, зөрчил² илрүүлж, аудитын явцад 1,443.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,600.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож аудитын явцад төлөгдсөн, 509,054.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад орлого бууруулсан 1,197.7 мянган төгрөг, хүүхдийн хоолны зардал бууруулсан 245.4 мянган төгрөгийг тус тус залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд эрхлэгчийн тушаалаар цалингийн зардлаас ахмадын санд 5,600.0 мянган төгрөг шилжүүлсэн байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дах заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

- 2022 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт нийт 148 мэдээлэл оруулахаас 209,075.6 мянган төгрөгийн 4 мэдээлэл хугацаа хоцорч мэдээлсэн, 142 мэдээлэл хугацаандаа мэдээлж, 2 мэдээллийг оруулах хугацаа болоогүй байна.
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 315,625.3 мянган төгрөгийн 20 гүйлгээний мэдээлэл оруулахаас 243,527.3 мянган төгрөгийн 13 мэдээлэл мэдээлээгүй, орлогын 55,698.0 мянган төгрөгийн 5 гүйлгээг буруу дүнгээр мэдээлсэн байна. Энэ нь Шилэн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд нь бүрэн мэдээлж хэвших

2. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардлаас тээвэр шатахууны зардалд 754.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Илрүүлэлт:

Тус цэцэрлэг нь малчинтайгаа жил бүр гэрээгээ шинэчилж хийдэггүй, цалин хөлсөө тохироогүй жилийнхээ төлийг цалинд өгч байгаа нь 58 толгой мал маллахад цалин хөлс өндөр байна мөн мал нь төлөө орлого авдаггүйгээс сүргийн эргэлтэнд орохгүй хөгширөх эрсдэл өндөр, малаас авах үр ашгийн тооцоо хийгээгүйгээс ноос, ноолуур болон сүү цагаан идээ орлого аваагүй байна. Мөн малаа ээмэгжүүлж, зүсмийн бүртгэл хийгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1 дэх заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Туслах аж ахуйн малын төл болон малаас гарах ашиг шимийг нягтлан бодох бүртгэлд бүртгэх, малчинтай хөдөлмөрийн гэрээтэй хамт үйлдвэрлэлийн төлөвлөгөө хийж батлуулан малаас авах үр ашгийг тооцож ажиллах, мөн малаа ээмэгжүүлж, малын зүсмийн бүртгэл хөтлөх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүртгэлийн алдаа	2	1,443.2	0	0	0	0	2	1,443.2	0	0	0	0
Дүн	2	1,443.2	0	0	0	0	2	1,443.2	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах	Хууль, хяналтын

									албан шаардлага		байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй	1	754.0	0	0	0	0	1	754.0	0		0	0
Малын төл болон малын ашиг шимийг бүртгэлд тусгаагүй	1	0	0	0	0	0	1	0	0		0	0
Дүн	2	754.0	0	0	0	0	2	754.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хугацаа хоцроож мэдээлсэн	4	209,075.6	0	0	0	0	1	508,300.9
Буруу дүнгээр мэдээлсэн	5	55,698.0						
Мэдээлээгүй	13	243,527.3	0	0	0	0		
Дүн	22	508,300.9	0	0	0	0	1	508,300.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллаагүй	1	5,600.0	1	5,600.0	0	0	0	0
Дүн	1	5,600.0	1	5,600.0	0	0	0	0
Нийт дүн	23	513,900.9	1	5,600.0	0	0	1	508,300.9

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ПАРТНЕР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Л.МАНДАХНАРАН ОГНОО:

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: 2023.02.18